



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/50/НА-СТА-ТХН

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 260512 Цахим хаяг: Chantsaldulamp@audit.gov.mn
Аудитор: Б.Тэгшсүрэн
Утас: 261740 Цахим хаяг: tegshsurenb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эйч Эл Би Монголиа Аудит ХХК
Захирал: Ч.Энхтуяа
Цахим хаяг: enkhtuya@hlb.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МХТ	Мэдээлэл Холбооны Технологи
ТЕГ	Татварын Ерөнхий Газар
ТНМС	Татварын Нэгдсэн Мэдээллийн Систем
ТХОНМС	Төсвийн Хөрөнгө Оруулалтын Нэгдсэн Мэдээллийн Систем
ТХОГ	Төсвийн Хөрөнгө Оруулалтын Газар
ТХОУ	Төсвийн Хөрөнгө Оруулалтын Удирдлага
ТХОУМС	Төсвийн Хөрөнгө Оруулалтын Удирдлагын Мэдээллийн Систем
ТУНС	Татварын Удирдлагын Нэгдсэн Систем



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.03 № 06/942
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн Газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд байгуулсан 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 3709-МОН дугаартай зээлийн гэрээний дагуу 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусгавар болгон хаагдах байсныг 2025 оны 05 дугаар сарын 14-ны өдөр Азийн Хөгжлийн банкнаас 2027 оны 09 дүгээр сарын 30-наар дуусгавар болгохоор сунгасан байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн нийт санхүүжилтийн хэмжээ 27,330,000.0 ам.доллар бөгөөд Азийн Хөгжлийн Банкны санхүүжилт 25,000,000.0 ам.доллар, Монгол Улсын Засгийн газрын санхүүжилт 2,330,000.0 ам.доллар байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Азийн Хөгжлийн Банкны зээлийн хөрөнгөөр бий болсон Татварын удирдлага болон төсвийн хөрөнгө оруулалтын мэдээлэл холбоо технологийн тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 792 дугаар тогтоолоор Монгол Улсын Сангийн яаманд 1,807,810.9 мянган төгрөгийн барилга байгууламжийг хүлээлгэн өгсөн байна.

Тайлант онд төсөл хэрэгжүүлэгч нэгж 3 бүрэлдэхүүний нийт 27 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 76.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,885,944,978.05	6,639,183,202.32
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,217,509,316.36	1,271,471,344.28
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	1,217,509,316.36	1,271,471,344.28
31210	Төгрөг	15,553,364.10	6,993,354.44
31211	Төрийн сангийн харилцах	15,553,364.10	6,993,354.44
31220	Гадаад валют	1,201,955,952.26	1,264,477,989.84
31221	Төрийн сангийн харилцах	1,201,955,952.26	1,264,477,989.84
34	УРЬДЧИЛГАА	288,200,735.24	-
34600	Урьдчилж гарсан зардал	288,200,735.24	-
35	БАРАА МАТЕРИАЛ	-	152,902,704.00
35440	Түлш, шатах тослох материал	-	2,704.00
35470	Бусад хангамжийн материал	-	152,900,000.00
36	Бусад эргэлтийн хөрөнгө	3,380,234,926.45	5,214,809,154.04
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	3,380,234,926.45	5,214,809,154.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	122,031,301.68	99,563,712.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	122,031.301.68	99,563,712.24
39200	Биет бус хөрөнгө	121,893,801.58	99,563,712.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	179,300,000.00	179,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(80,685,000.00)	(98,615,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,499,201.80	54,499,201.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,222,785.97)	(48,598,011.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,338,635.00	34,658,635.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,336,249.25)	(21,681,112.75)
39300	Биет бус хөрөнгө	137,500.10	-
39301	Программ хангамж	15,022,370.16	15,022,370.16
39302	Хуримтлагдсан элэгдэл	(14,884,870.06)	(15,022,370.16)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,007,976,279.73	6,738,746,914.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	75,300.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	75,300.00
41360	Бусад өглөг	-	75,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	75,300.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,007,976,279.73	6,738,671,614.56
51	Засгийн газрын хувь оролцоо	5,007,976,279.73	6,738,671,614.56
51200	Хуримтлагдсан үр дүн	5,007,976,279.73	6,738,671,614.56
51210	Өмнөх үеийн үр дүн	14,180,581,556.20	8,374,051,756.29
51220	Тайлант үеийн үр дүн	(9,172,605,276.47)	(1,635,380,141.73)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,007,976,279.73	6,738,746,914.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,978,019,940.05	3,191,715,250.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,978,019,940.05	3,191,715,250.55
120	Нийтлэг татварын бус орлого	10,978,019,940.05	3,191,715,250.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,977,866,939.50	3,147,076,995.13
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	9,925,995,259.94	3,147,076,995.13
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,051,871,679.56	-
120009	Бусад орлого	153,000.55	44,638,255.42
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,823,200,657.09	1,859,589,228.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,823,200,657.09	1,859,589,228.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,823,200,657.09	1,859,589,228.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,054,665.26	416,246,324.67
210101	Үндсэн цалин	417,054,665.26	416,246,324.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,131,833.14	51,939,942.07
210201	Тэтгэврийн даатгал	52,131,833.14	51,939,942.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,505,440.00	124,606,960.00
210304	Байрны түрээс	84,505,440.00	124,606,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,859,018.65	16,688,426.27
210401	Бичиг хэрэг	4,750,300.00	2,220,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,218,718.65	14,282,926.27
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	890,000.00	185,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,895,428.55	10,832,296.00
210702	Дотоод томилолт зардал	4,895,428.55	10,832,296.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,211,875,142.64	799,171,003.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,190,955,134.64	777,824,227.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,840,000.00	15,840,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,883,960.00	4,804,532.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	702,244.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	22,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,879,128.85	440,104,275.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	416,316,686.36
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,879,128.85	23,787,589.44
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	8,154,819,282.96	1,332,126,021.94
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	18,155,866.29	13,151,507.66
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	18,155,866.29	13,151,507.66
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17,345,580,425.72	2,980,657,671.33

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	17,345,580,425.72	2,980,657,671.33
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(17,327,424,559.43)	(2,967,506,163.67)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(9,172,605,276.47)	(1,635,380,141.73)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,066,491,696.35	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,066,491,696.35	-
120	Нийтлэг татварын бус орлого	4,066,491,696.35	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,066,491,696.35	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,066,491,696.35	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,795,027,601.38	2,659,883,920.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,795,027,601.38	2,659,883,920.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,795,027,601.38	2,659,883,920.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,054,665.28	416,244,767.04
210101	Үндсэн цалин	417,054,665.28	416,244,767.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,131,833.17	51,939,942.03
210201	Тэтгэврийн даатгал	35,449,646.55	35,319,160.87
210202	Тэтгэмжийн даатгал	4,170,546.65	4,155,195.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,085,273.33	2,077,597.70
210204	Ажилгүйдлийн даатгал	2,085,273.33	2,077,597.70
210205	Эрүүл мэндийн даатгал	8,341,093.31	8,310,390.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,505,440.00	124,606,960.00
210304	Байрны түрээс	84,505,440.00	124,606,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,199,018.65	16,688,426.27
210401	Бичиг хэрэг	4,750,300.00	2,220,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,218,718.65	14,282,926.27
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	230,000.00	185,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,778,900.00	3,129,700.00
210604	Урсгал засвар	7,778,900.00	3,129,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,740,000.00	10,835,000.00
210702	Дотоод албан томилолт	4,740,000.00	10,835,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,205,617,744.28	2,036,439,124.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,184,697,736.28	2,015,105,648.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,840,000.00	15,840,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,883,960.00	4,804,532.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	688,944.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,271,464,094.97	(2,659,883,920.32)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	295,382,112.00	446,382,554.55
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	295,382,112.00	446,382,554.55
2200	Дотоод эх үүсвэрээр	295,382,112.00	446,382,554.55

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
220001	Барилга байгууламж	80,836,657.00	-
222001	Тоног төхөөрөмж	214,545,455.00	446,382,554.55
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(295,382,112.00)	(446,382,554.55)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	18,155,866.29	3,160,228,502.79
14	Бусад эх үүсвэр	18,155,866.29	3,160,228,502.79
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	18,155,866.29	13,151,507.66
1451	Засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	3,147,076,995.13
145102	Бусад засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	3,147,076,995.13
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	994,237,849.26	53,962,027.92
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	223,271,467.10	1,217,509,316.36
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,217,509,316.36	1,271,471,344.28

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	14,180,581,556.20	14,180,581,556.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	14,180,581,556.20	14,180,581,556.20
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(9,172,605,276.47)	(9,172,605,276.47)
2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	5,007,976,279.73	5,007,976,279.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,366,075,476.56	3,366,075,476.56
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	8,374,051,756.29	8,374,051,756.29
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,635,380,141.73)	(1,635,380,141.73)
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	6,738,671,614.56	6,738,671,614.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,179,583,700.00	3,106,266,474.87	73,317,225.13	97.7
УРСГАЛ ЗАРДАЛ	2,733,083,700.00	2,659,883,920.32	73,199,779.68	97.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,733,083,700.00	2,659,883,920.32	73,199,779.68	97.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,200,000.00	416,244,767.04	2,955,232.96	99.3
Үндсэн цалин	419,200,000.00	416,244,767.04	2,955,232.96	99.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,400,000.00	51,939,942.03	460,057.97	99.1
Тэтгэврийн даатгал	35,632,000.00	35,319,160.87	312,839.13	99.1
Тэтгэмжийн даатгал	4,192,000.00	4,155,195.40	36,804.60	99.1
ҮОМШӨ-ний даатгал	2,096,000.00	2,077,597.70	18,402.30	99.1
Ажилгүйдлийн даатгал	2,096,000.00	2,077,597.70	18,402.30	99.1
Эрүүл мэндийн даатгал	8,384,000.00	8,310,390.36	73,609.64	99.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	124,650,000.00	124,606,960.00	43,040.00	99.9
Байрны түрээс	124,650,000.00	124,606,960.00	43,040.00	99.9
Хангамж, бараа материалын зардал	16,800,000.00	16,688,426.27	111,573.73	99.3
Бичиг хэрэг	2,300,000.00	2,220,500.00	79,500.00	96.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,300,000.00	14,282,926.27	17,073.73	99.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	185,000.00	15,000.00	92.5
Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,000.00	3,129,700.00	70,300.00	97.8
Багаж, техник, хэрэгсэл	3,200,000.00	3,129,700.00	70,300.00	97.8
Томилолт, зочны зардал	10,900,000.00	10,835,000.00	65,000.00	99.4
Дотоод албан томилолт	10,900,000.00	10,835,000.00	65,000.00	99.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,105,933,700.00	2,036,439,124.98	69,494,575.02	96.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,084,500,000.00	2,015,105,648.98	69,394,351.02	96.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,840,000.00	15,840,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	4,900,000.00	4,804,532.00	95,468.00	98.0
Тээврийн хэрэгслийн татвар	693,700.00	688,944.00	4,756.00	99.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	446,500,000.00	446,382,554.55	117,445.45	99.9
Тоног төхөөрөмж	446,500,000.00	446,382,554.55	117,445.45	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,179,583,700.00	3,147,076,995.13	32,506,704.87	98.9
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,179,583,700.00	3,147,076,995.13	32,506,704.87	98.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,217,509,316.36		

Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төсвийн тохируулга		13,151,507.66		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,271,471,344.28		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	8	8	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн санхүүжилтийн нийт хэмжээ 27,330.0 мянган ам.доллар, үүнээс АХБ буюу гадаад зээлийн эх үүсвэрээс 25,000.0 мянган ам.долларыг, Монгол Улсын Засгийн Газар буюу мөнгөн бус оролцоогоор 2,330.0 мянган ам.долларыг санхүүжүүлэхээр батлагдсан. Төсөл хөтөлбөрийн захиалагч нь Сангийн Яам, 2027 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хэрэгжүүлэх ба төслийн үйл ажиллагааны нийт хэрэгжилт 92.6 хувьтай байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь татварын удирдлага болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын өнөөгийн МХТ-ийн дэд бүтцийн хэрэгцээг тодорхойлж сайжруулахад шаардлагатай үйл ажиллагааг дэмжих замаар татварын удирдлага болон ТХОГ-ын тогтолцооны үр өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилготой болно.

Төслийн үйл ажиллагаа нь дараах гурван бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваагдана. Үүнд:

- Татварын удирдлага болон төсвийн хөрөнгө оруулалтын бизнес үйл явцыг оновчтой болгон сайжруулах
- Татварын удирдлага болон төсвийн хөрөнгө оруулалтын МХТ-ийн тогтолцоог сайжруулах
- ТУНС болон ТХОНМС-үүдийг хариуцан ажиллах Засгийн газрын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх зэрэг болно.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Төсвийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон;
- Сангийн сайдын 2025 оны 01 сарын 03-ний өдрийн А/3 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ын журам”;

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ний өдөр А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ийн дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудад өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,730,770.6 мянган төгрөгөөр буюу 27.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б		2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,217,509.3	1,271,471.4	53,962.0
Урьдчилж гарсан зардал	288,200.7	-	(288,200.7)
Бараа материал	-	152,902.7	152,902.7
Бусад эргэлтийн хөрөнгө	3,380,234.9	5,214,809.1	1,834,574.2
Үндсэн хөрөнгө	122,031.3	99,563.7	(22,467.6)
Нийт хөрөнгө	5,007,976.2	6,378,746.9	1,730,770.6
Өр төлбөр	-	75.3	75.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,007,976.2	6,378,671.6	1,730,695.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,007,976.2	6,378,746.9	1,730,770.6

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данстууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,271,471.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 53,962.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гадаад эх үүсвэрээс 3,147,077.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч урсгал зардал болон хөрөнгийн зардалд 3,106,266.4 мянган төгрөгийг зарцуулж, гадаад валютын ханшийн зөрүүний олз 13,151.5 мянган төгрөгийн бүртгэсэнтэй холбоотой байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 288,200.7 мянган төгрөгөөр буурсан нь 2025 оны 03 сард Итали улсад болсон хөрөнгө оруулалтын тэргүүн туршлага судлах албан ажлаар гадаад томилолтоор ажиллаж 124,120.7 мянган төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрсөн, Эйч Эс Эн ХХК-иас санхүүгийн удирдлагын цахим системийг олон нийтэд таниулах 164,080.0 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч бүртгэсэн зэргээс голлон шалтгаалсан.

Бараа материал дансны үлдэгдэл 152,902.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь санхүүгийн удирдлагын цахим системийг олон нийтэд таниулах сургалтын материал, тараах материал, сургалтын хэрэглэгдэхүүнийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 5,214,809.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,834,574.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 5,203,998.8 мянган төгрөгийн гэрээт ажлын

төлбөр, 44,638.2 мянган төгрөгийн гааль, татварын чөлөөлөлтийг тус тус нэмж бүртгэсэнтэй холбоотой. Мөн ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 792 дугаар тогтоолоор Сангийн яамны төрийн захиргаа, удирдлагын газарт 1,807,811.0 мянган төгрөгийн Санхүүгийн нэгдсэн дата төвийн барилга байгууламж, 676,869.9 мянган төгрөгийн сүлжээний тоног төхөөрөмж, ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-1/2397 тоот бичиг болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Хөрөнгө шилжүүлэх тухай” албан бичгээр 929,381.8 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн өгснөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,378,671.6 мянган төгрөгт хүрч, 1,730,695.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын эх үүсвэрээс 3,179,583.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналыг хянаж, Сангийн яамнаас урсгал зардлыг 2,733,083.7 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 446,500.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөл хэрэгжүүлэх нэгжийн 3 бүрэлдэхүүний 7 багцын 24 төсөл арга хэмжээ, зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхээр мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,217,509.3 мянган төгрөг, гадаад зээлийн эх үүсвэрээс 3,147,077.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 2,659,884.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 446,382.5 мянган төгрөгийг зарцуулж, гадаад валютын ханшийн зөрүүний олз 13,151.1 мянган төгрөгийн хүлээн зөвшөөрч мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,271,471.3 мянган төгрөг байна.

Нийт зардлын гүйцэтгэл 3,106,266.5 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байна. Үүнээс цалингийн зардалд 468,184.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 124,606.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 16,688.4 мянган төгрөг, багаж техник хэрэгсэлд 3,129.7 мянган төгрөг, томилот зочны зардалд 10,835.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 2,036,439.1 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 446,382.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Урсгал зардалд 73,317.2 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 117.4 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	70207	Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	3,179,583.7	3,106,266.5	73,317.2	97.7

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
2	80104	Үйл ажиллагааны зардал	2,733,083.7	2,659,884.0	73,199.7	97.3
3	80918	Хөрөнгийн зардал	446,500.0	446,382.5	117.5	99.9

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус төсөл хэрэгжүүлэгч нэгжээс дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Үүнд:

- Төслийн Удирдах Хорооны 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 07/01 тоот тушаалын дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжид 8 орон тоо баталснаас гүйцэтгэлээр орон тоо бүрэн ажилласан байна.
- Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 3 дугаар бүрэлдэхүүн ажлын хүрээнд Сангийн яамны Санхүүгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх сургалтанд 314,154.2 мянган төгрөг, Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн системийн ажилчдын техникийн чадавхыг бэхжүүлэх сургалтанд 99,988.6 мянган төгрөг, ТХОНМС-ийн дэд бүтцийн салбарын Сангийн яамны техникийн ажилтнуудын техникийн чадавхыг бэхжүүлэх сургалтанд 37,731.3 мянган төгрөг, ТХОНМС-ийн хэрэглэгчдэд зориулсан чадавхыг бэхжүүлэх сургалтанд (Яам, аймаг, дүүргийн түвшний хэрэглэгчид болон бусад шаардлагатай оролцогч талуудад зориулсан сургалт) 96,364.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, унаа хоолны хөнгөлөлт, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь дотоод хяналтын системийг ашигладаг бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны нийт хэрэгжилт 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 92.6 хувьтай байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн хүрэх үр дүн, үе шат

№	Бүрэлдэхүүн	Хүрэх үр дүн	Биелэлт	Хэрэгжилт
1	Татварын удирдлагын болон төсвийн хөрөнгө оруулалтын өнөөгийн бизнес процессыг олон улсын сайн туршлагатай нийцүүлэн сайжруулах	Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд: 1. Татварын удирдлагын өнөөгийн бизнес процессыг шинжлэн сайжруулах арга замыг тодорхойлох, шинээр боловсруулсан бизнес процесст үндэслэн илүү ил тод, үр ашигтай ТУНС-ийг хөгжүүлж ашиглалтад нэвтрүүлэх ба хуучин системүүдтэй холбосноор мэдээлэл шилжүүлэх, веб суурилсан нэгдсэн мэдээллийн найдвартай сан бий болгон удирдлагыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх; 2. Төсвийн хөрөнгө оруулалтын бизнесийн үйл явцыг судалж оновчтой болгох шийдлийг санал болгосноор	ТУНС-ийн бизнес процесс ба системийн сайжруулалтын гарын авлагыг 2017 оны 12 дугаар сард ТЕГ-аас ажлын хэсэг байгуулан ажиллаж эхэлсэн ба татварын удирдлагын нэгдсэн системийн бизнес процесс ба системийн сайжруулалтын гарын авлагыг 2018 оны 12 дугаар сард батлан хэрэгжүүлж эхэлсэн. Тус гарын авлага нь татварын албаны үйл ажиллагаа, татвар хураалт ба өрийн удирдлага, татвар төлөлт ба арилжааны банк, татвар төлөгчийн бүртгэл, тайлан боловсруулалт, татварын маргаан хянан шийдвэрлэх, хяналт шалгалт, ухаалаг тайлангийн систем, татварын албаны үйл ажиллагааны дотоод эрсдэлийн тооцоолол, татвар төлөгчийн эрсдэлийн тооцоолол, эрдэс баялаг, уул уурхайн үйл ажиллагааны бүртгэл,	100%

Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	Бүрэлдэхүүн	Хүрэх үр дүн	Биелэлт	Хэрэгжилт
		Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын мэдээллийн систем (ТХОУЦС)-ийг хөгжүүлэх, туршин нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх;	татварын орлогын бүртгэл, татварын буцаан олголт, сургалтын үйл ажиллагаа, олон улсын татвар, дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хандалт, лог бүртгэл зэргийг бүрэн хамарсан цогц гарын авлагыг боловсруулан Сангийн яам хянан үзэж 2023 оны 07 дугаар сард батлагдсан байна.	
2	Татварын удирдлага болон төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн системийг бий болгон нэвтрүүлэхэд шаардлагатай МХТ-ийн бүтцийг сайжруулах	Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд: 1.ТУНС-ийн найдвартай хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд МХТ-ийн дэд бүтцийн тоног төхөөрөмж, программ хангамжийг нийлүүлэх, МХТ-ийн бус тоног төхөөрөмж нийлүүлэх суурилуулах замаар ТУНС-ийн найдвартай ажиллагааг хангах 2. ТХОУЦС-ийг нэвтрүүлэхэд чиглэсэн МХТ-ийн тоног төхөөрөмж, программ хангамж нийлүүлэх, Сангийн яамны дэргэд санхүүгийн мэдээллийн технологийн дата төв байгуулах	2025 оны 4 дүгээр сард PIMIS хувилбар 4.0 хөгжүүлэлт хийгдсэн бөгөөд гүйцэтгэгч, зураг төсөв зохиогчийн хяналт, захиалагч, Сангийн яам, иргэдийн оролцоо, контент удирдлага, системийн тохиргоо, удирдлага гэсэн заавал байх 8 элементийг нэвтрүүлэн улмаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг PIMIS системд бүрэн шилжүүлсэн байна. Төсвийн хөрөнгө оруулалтын веб сайт, гар утасны аппликейшн дээр улсын төсвөөс гадна Гадаад, зээл тусламж, Нийслэлийн төсөв, Орон нутгийн төсөв болон Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллүүдийг ил тод, нээлттэй болгож төслүүдийг дахин давтагдашгүйгээр кодолсон байна. 2025 оны 4-р улирлын байдлаар систем хөгжүүлэлтийн нийт явц 73%-д хүрсэн байна. 2025 оны 4-р улирлын байдлаарх системийн үндсэн статистик мэдээллээр нийт хэрэглэгчийн тоо 32,479 бөгөөд үүнээс 2,907 нь гүйцэтгэгч, 1,111 нь захиалагч, 705 нь хяналтын инженер, 26,737 нь хувь хэрэглэгч байна.	93.0%
3	ТУНС болон ТХОУЦС-ийг хариуцан ажиллах Засгийн газрын ажилтнуудын чадавх бэхжүүлэх	Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд: 1.Мэдээллийн технологийн систем-хэрэглэгчийн сургалт, 2.Системд суурилсан удирдлагын сургалт, 3.Систем, түүний процессын засвар үйлчилгээ, сайжруулалттай холбоотой сургалтыг тус тус зохион байгуулахаар төлөвлөсөн.	Энэ бүрэлдэхүүний 3 бүлгийг хамарсан нийт 107 удаагийн сургалт арга хэмжээг зохион байгуулж, нийт 3,880.0 хүн хамрагдсанаас 2,039.0 буюу 52.5 хувь нь эмэгтэй хүн байна. 2025 оны 6 сарын 6-ны өдөр ТХОУЦС-ийн хэрэглэгчийн сургалтыг 21 аймаг, сумд, яам, агентлагийн хөрөнгө оруулалт хариуцсан 216 мэргэжилтнүүдэд зохион байгуулан ажилласан байна.	81.6%

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн ахлах аудитор А.Билгүүн, аудитор П.Ганчимэг, нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Р.Энх-Амгалан, захирал Ч.Энхтуяа нар анхан шатны хяналтыг, Үндэсний Аудитын Газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Тэгшсүрэн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний Аудитын Газарт 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 02/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,840,246.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 48,402.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянах зорилгоор аудитаар төлөвлөгдсөн нийт 76 заалтаас төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаанд хамааралтай 32 заалтыг түүвэрлэж, Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хязгаарласан заалтуудад горим сорил хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх нэгжээс шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 26 төрлийн 156 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ТХОУЦС болон мэдээлэл харилцаа, технологийн системүүдийг баталгаажуулах гуравдагч талын аудитын зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа эсэх тэдгээрийн үр дүн хэрэгжилтийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33,954.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс залруулагдаагүй 33,954.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,448.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цахим төлбөрийн баримтын бүртгэлтэй холбоотой:

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн журналаас 2,296,616.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг түүвэрлэн цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 33,954.0 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээг и баримтын цахим системээр баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д "Аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил үйлчилгээний төлбөрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулан ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн хөрөнгийн журналаас 2,296,616.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг түүвэрлэн цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 33,954.0 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээг ибаримтын цахим системээр баталгаажаагүй байна.	1	33,954.0	-	-	-	-	1	33,954.0	-	-	-	-
	Дүн	1	33,954.0	-	-	-	-	1	33,954.0	-	-	-	-